

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 10 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Монгол Улсын Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, боомтын сэргэлтийн хүрээнд хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, экспортыг эрчимжүүлэх, Оюу толгойн гүний уурхайн олборлолт хийгдэж, зэсийн баяжмалын агууламж өссөнөөр уул уурхай, түүнийг дагасан тээвэр логистик, худалдааны салбарын өсөлт нэмэгдэх, ингэснээр экспортын орлого өсөж, төлбөрийн тэнцэл сайжрах, гадаад валютын албан нөөц нэмэгдэж, валютын ханш тогтворжих зэргээр макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд эергээр нөлөөлөхөөс гадна төсвийн орлого нэмэгдэхээр хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, эдийн засгийн бодит өсөлт, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, Засгийн газрын өрийн нийт хэмжээг нэмэгдүүлж байгаа шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн төсвийн хүрээний мэдэгдлийн эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн тооцоолол бодитой эсэх, төсвийн бодлого мөнгөний бодлоготой уялдсан эсэх, хэрэглээний үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хэрхэн хамгаалах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир өмнөх жилүүдийн төсвийн хүрээний мэдэгдлээр баталсан тоон үзүүлэлт нь гүйцэтгэлийн дүнтэй нийцсэн эсэх, төсвийн алдагдлын эх үүсвэрийг хэрхэн тооцсон, хэрэглээний үнийн өсөлттэй уялдуулан зардлыг бодитоор төлөвлөж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж төсвийн зардлын тэлэлт нь хэрэглээний үнийн өсөлтөд шууд нөлөөлж, бараа бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлж байгаа тул ирэх оны төсвийн хүрээний мэдэгдлийг мөнгөний бодлоготой уялдуулсан эсэх талаар төсөл санаачлагчаас асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь махны үнийг чөлөөлж, төрөөс махыг экспортлоход зоригтой шийдэл гаргаснаар төвлөрлийг бууруулж, орон нутгийг дэмжих боломж бүрдэнэ гэсэн санал хэлсэн болно.


Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72.7 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Г.ТЭМҮҮЛЭН